



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 87

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө олж авах зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын яам, түүний харьяа байгууллагуудын албан ажлын хэрэгцээнд зориулан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 48 ширхэг автомашиныг 2,000,000,000.00 /хоёр тэрбум/ төгрөгт багтаан худалдан авахыг зөвшөөрч, худалдан авах автомашины техникийн үзүүлэлт, үнийн дээд хязгаарыг хавсралтаар баталсугай.

2. Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Хуулийн хэлтсийн дарга Л.Цэдэвсүрэнд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.НАРАНГЭРЭЛ

0000132

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн
...87... дугаар тогтоолын хавсралт

**Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам түүний харьяа байгууллагуудад
худалдан авах автомашины техникийн үзүүлэлт, үнийн дээд хязгаар**

Д/д	Автомашины техникийн үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)
1	Суудлын автомашин /суудлын тоо 5, 4608сс хөдөлгүүрийн багтаамжтай/	ш	1	262,300,000.00	262,300,000.00
2	Суудлын автомашин /суудлын тоо 5, 1999 сс хөдөлгүүрийн багтаамжтай/	ш	2	120,500,000.00	241,000,000.00
3	Суудлын автомашин /суудлын тоо 10, 2700 сс хөдөлгүүрийн багтаамжтай/	ш	45	33,260,000.00	1,496,700,000.00
	Нийт үнэ		48		2,000,000,000.00 (хоёр тэрбум)